



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

┌ Тусгай горимд шилжүүлэх тухай ┐

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ажиллах нийт ажилчдын ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулж, 2021 оны 1-р сарын 17-ны өдрөөс тусгай горимд шилжүүлэн ажиллуулсугай.

2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ажиллах зохион байгуулалтын журмыг нэгдүгээр, тусгай горимоор ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг алба тасгийн дарга эрхлэгч нарт, тусгай горимд шилжүүлсэнтэй холбогдуулан нийт ажилчдыг цахимаар ажиллахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхийг Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн технологийн албаны дарга /Д.Алтантогтох/-д үүрэг болгосугай.


4. Тусгай горимд хэсэгчлэн шилжүүлсэнтэй холбогдуулан нийт ажилчдын цаг ашиглалтыг бүртгэж баталгаажуулан хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба /Ц.Энхбаяр/-т, цалин урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бодож олгохыг ерөнхий нягтлан бодогч /З.Ууганцэцэгт/-д тус тус даалгасугай.

5. Уг тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг дэд захирал /Б.Амгаланбаяр/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ



Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн тусгай горимд шилжин ажиллах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед нийт ажилчдыг халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ажилчдын дундаас нэгдүгээр хавьтал, сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдсэн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэвийн горимоор тасралтгүй үзүүлэх үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмыг Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед төвийн хэмжээнд мөрдөн ажиллана.
- 1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үеийн шуурхай хариу арга хэмжээний баг тусгай горимын дагуу, лабораторийн тусламж, үйлчилгээний баг, дуудлага хяналтын бага эмч, сангийн слесариуд батлагдсан хуваарийн дагуу тусгай горимд шилжин ажиллана.
- 1.4. Журмын 1.3 - т зааснаас бусад ажилчид хуваарийн дагуу хоёр ээлжийн тусгай горимд шилжих ба энэ нь ажлын 5 хоногоор тооцогдоно.
- 1.5. Төвийн удирдлагын зөвлөлийн хурал, шуурхай хурал, уулзалт, албан бичиг хэрэг хөтлөлт, өдөр тутмын үйл ажиллагаа, төлөвлөгөө түүний хэрэгжилтийг цахимаар хийж гүйцэтгэх ба хариуцсан алба тасгийн дарга, эрхлэгч нэгдсэн удирдлагаар тухай бүр хангаж, удирдлагад мэдээлнэ.
- 1.6. Хэрэв тухайн ээлжийн ажилчдаас батлагдсан тохиолдлын нэгдүгээр хавьтал, халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол илэрсэн үед үйл ажиллагааг бүрэн зогсоож, шуурхай хариу арга хэмжээг ЗМА-ТУТ-ны 2020 оны 08 дугаар тушаалын дагуу ерөнхий захирал, дэд захирлын зааварчилгаагаар НЭМТШУ-ын албаны дарга болон түүнийг орлох албан тушаалтан хариуцан байгууллагын хэмжээнд тандалт судалгаа хийж, хавьталын судалгааг хийж гүйцэтгэсний дараа байгууллагад голомтын эцсийн халдваргүйжүүлэлт хийж, дараагийн ээлжид мэдээлнэ. Уг ээлж нь өмнөх ээлжийн тусгаарлах хугацаа дуустал төвийн үйл ажиллагааг зохисон байгуулна.
- 1.7. Цар тахлын нөхцөл байдал хүндэрч, ачаалал хэтэрсэн үед тухайн ээлжид ажиллаж буй ерөнхий захирал, дэд захирлын зааварчилгаагаар шуурхай


хурал зарлан цахимаар хуралдаж нийт ажилчдыг дуудан ажиллуулах шийдвэрийг гаргах ба нийт ажилчид байнгын бэлэн байдалд байна.

Хоёр. Нийт ажилтнуудын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Тусгай горимоор тухайн долоо хоногт байгууллага дээр ажиллах ажилчдын дунд лабораторит суурилсан тандалтыг зохион байгуулж даваа гарагийн өглөө бүр уг өдрийн ээлжинд гарч буй лабораторийн баг нь эмнэл зүйч эмч болон түүнийг орлон ажиллах ажилтантай хамтран сорьц авч SARS-CoV-2 вирус илрүүлэх молекул биологийн (PCR) шинжилгээнд хамруулан хариу гарсан даруйд цахимаар нийт ажилчдад мэдээлнэ.
- 2.2. Тусгай горимоор ажиллах хугацаанд нэгжийн удирдлагууд болон ээлж ахлан ажиллаж буй эмч нар дараагийн ээлжийн хийх ажлыг цахим аппликейшн болон гар утас ашиглан мэдээлэл дамжуулж, солилцох ба ээлж солилцохдоо халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зайлшгүйгээс бусад нөхцөлд хоорондоо уулзахгүйгээр тухай бүр зохицуулалтыг хийнэ.
- 2.3. Тусгай горимоор ажиллах нь ажил цалгардуулах үндэслэл болохгүй бөгөөд гэрээс ажиллаж байгаа ажилчид гар утсаа байнга нээлттэй байлгаж, алба тасгийн хэрэглэж буй харилцааны цахим хэрэгслээр дамжуулан тухай бүр хариу өгч, ажил үүргийг гүйцэтгэнэ.
- 2.4. Гэрээр ажиллаж буй мэргэжилтнүүд өдөр бүр ажлын цагийг цахимаар дүрсжүүлж бүртгүүлнэ.
- 2.5. Нийт ажилчид өөрийн гар утас болон компьютерт цахим харилцааны *viber, telegram, google meet* зэрэг аппликейшныг ашиглан ажлыг тасралтгүй явуулах үүргийг хүлээнэ.
- 2.6. Орлуулшгүй ажил үйлчилгээг өөрийн биеэр хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хариуцсан нэгжийн даргад мэдээлж, тухай бүр ажлын зохицуулалтыг хийнэ.
- 2.7. Байгууллага дээр ажиллах хугацаандаа ажил үйлчилгээ явуулахаас бусад нөхцөлд өөр өрөө тасалгаанд орох, хоорондоо уулзах, удирдлагын зөвшөөрөлгүйгээр хурал зөвлөгөөн хийх, бүлгийн уулзалт болон тэмдэглэлт үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.
- 2.8. Тусгай горимоор байгууллага дээр ажиллахаас бусад үед зайлшгүй шаардлагагүй бол оршин суугаа хаягаас өөр чиглэлд зорчих, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцохгүй байж хувийн халдвар хамгааллын дэглэмийг чанд сахина.
- 2.9. Ажилтан бүр сүүлийн 14 хоногт бусад ээлжийн ажилчид, гадуур уулзсан хүмүүс болон явсан маршрутын талаарх мэдээллийг тогтмол хөтөлнө.

- 2.10. Ажилтны гэр бүлийн гишүүд болон сүүлийн 14 хоногт уулзсан хүмүүсээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдлын нэгдүгээр хавьтал болсон тохиолдолд харьяалах нэгжийн даргад мэдээлж, хүнтэй уулзахгүйгээр гэрийн ажиглалтад 14 хоног тусгаарлагдана.
- 2.11. Ажилтны гэр бүлийн гишүүд болон сүүлийн 14 хоногт уулзсан хүмүүсээс Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдол бүртгэгдвэл яаралтай нэгжийн даргад мэдээлж, ажиглах байранд тусгаарлагдаж, тухайн ээлжид ажиллаж байгаа ажилчдад тандалт судалгааг хийж, гүйцэтгэн хоёрдугаар хавьтлуудыг илрүүлэх ба тэдгээр ажилчид 14 хоногийн гэрийн тусгаарлалтад байна.
- 2.12. Төвийн ажилтан бүр ээлжийн горим, албан тушаалаас үл хамааран 7 хоног тутмын үйл ажиллагааны тайланг баасан гарагт харьяалах нэгжийн бага эмч болон харьяалах нэгжийн даргаар дамжуулан дотоод сүлжээний 7 хоногийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл хавтсанд байршуулна.
- 2.13. Хэрэв ажилтан гэрийн болон ажиглах байранд тусгаарлалтад орсон нөхцөлд уг журмын дагуу цахимаар ажил үүргийг гүйцэтгэнэ.
- 2.14. Гэрээр ажиллаж буй ажилтнуудыг дараах тохиолдолд төвийн хэмжээнд мөрдөх бусад журмыг үл харгалзан ажил тасалсанд тооцно.
- 2.14.1. Тухайн өдөр цагийн бүртгэлийг хийлгээгүй, утас холбогдохгүй буюу нэг удаадаа 3-аас доошгүй удаагийн дуудлагыг аваагүй;
- 2.14.2. Тухайн долоо хоногийн ажлын гүйцэтгэлийг харьяалах нэгжийн хариуцсан мэргэжилтэнд ирүүлээгүй;
- 2.14.3. Өгсөн үүрэг даалгаврыг ээлжийн аль горимд ажиллаж байгаагаас үл харгалзан хугацаанд нь биелүүлээгүй.
- 2.14.4. Байгууллагаас зохион байгуулж буй цахим хурал зөвлөгөөнд оролцоогүй

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/05 дугаар тушаалын 1 хавсралт



ТУСГАЙ ГОРИМООР АЖИЛЛАХ АЖИЛТНУУДЫН ХУВААРЬ

№	1-р ээлж		2-р ээлж	
1. Захиргааны алба				
1	Захирал	Н.Цогбадрах	Дэд захирал	Б.Амгаланбаяр
2	Албаны дарга	Ц.Энхбаяр	Хүний нөөцийн мэргэжилтэн	Б.Отгоннавсо
3	Хүний нөөцийн менежер	Б.Баярмаа	Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	Э.Билгүүн
2. Нийгмийн эрүүл мэнд, тандалт, шуурхай удирдлагын алба				
4	Тархвар судлагч	Л.Роломжав	Албаны дарга	Д.Отгонбаяр
5	Тархвар судлагч	Г.Ганбилэг	Тархвар судлагч	Х.Ариунболд
6	Тархвар судлагч	Ц.Отгонцэцэг	Тархвар судлагч	Ш.Агиймаа
7	Тархвар судлагч	Э.Нарангарав	Тархвар судлагч	Ш.Сувд-Эрдэнэ
8	Амьтан судлагч	С.Мөнгөнбагана	Амьтан судлагч	Д.Батжав
9	Шимэгч судлагч	Ж.Батцэцэг	Шимэгч судлагч	М.Байгалмаа
10	Шимэгч судлагч	Б.Билгүүн	Амьтан судлагч	Б.Болор
11	Шимэгч судлагч	Ц.Ганхуяг	Амьтан судлагч	Б.Болорчимэг
12	Зоолаборант	Б.Цогбаяр	Эмнэл зүйч эмч	С.Оюунчимэг
13	Малын эмч	С.Отгонжаргал		
3. Эрдэм шинжилгээ, сургалт, мэдээллийн технологийн алба				
14	-	-	Албаны дарга	Д.Алтантогтох
15	ПХ-ын инженер	Б.Өлзийжаргал	ЭММТ	Б.Лхагвасүрэн
16	Сургалтын менежер	П.Алтангэрэл	Сургалтын лаборант	Б.Дарьсүрэн
17	Генетикч (судлаач)	Ч.Ганцэцэг	Амьтан судлагч	Ц.Баяр
18	Статистикч	Х.Бурмаа	Статистикч	О.Даариймаа
4. Ариутгал, халдваргүйтгэл, биоүйлдвэрлэлийн тасаг				
19	Тасгийн эрхлэгч	Х.Цэрэнсүрэн	Биотехнологич	Б.Хажидмаа
20	Тархвар судлагч	Г.Зулцэцэг	Ариутгагч	М.Нарантуяа
21	Ариутгагч	Д.Болормаа	Ариутгагч	Г.Алтанцэцэг
22	Ариутгагч	Н.Равжир	Бэлдмэлчин	Б.Сувд-Эрдэнэ
23	Бэлдмэлчин	Ш.Энхтуяа	Ариутгагч	П.Дэлгэрмаа
24	Үйлчлэгч	Б.Баяндүүрэн	Үйлчлэгч	Б.Цогзолмаа
25	Бэлдмэлчин	Б.Саранчимэг	Бэлдмэлчин	З.Тэгшжаргал
26	Үйлчлэгч	Д.Цэндсүрэн	Биотехнологич	Б.Батцэцэг
5. Чанарын алба				
27	Албаны дарга	У.Нармандах	Чанарын менежер	И.Отгончимэг
28	ЭЗЧХ-ын мэргэжилтэн	М.Оюунбилэг	АБЭХ менежер	Б.Саруул
6. Санхүү, хангамж, үйлчилгээний алба				
29	Ахлах нягтлан бодогч	З.Ууганцэцэг	АА-н менежер	Б.Батжаргал
30	Эдийн засагч	С.Мөнхчимэг	Тооцооны Ня-Бо	Э.Түвшинтулга
31	Кассын нярав	Б.Баярхүү	Аж ахуйн нярав	Б.Оргилтуул
32	Жолооч	Б.Пүрэв-Очир	Жолооч	Т.Батцэнгэл
32	Жолооч	Д.Түвшинзаяа	Жолооч	Д.Жамъяансүрэн
33	Жолооч	Б.Алтансүх	Жолооч	Ч.Лхагвасүрэн

34	Жолооч	Д.Ганзориг	-	-
----	--------	------------	---	---

7. Лабораторийн тусламж, үйлчилгээний баг

№	I Баг	II Баг	III Баг
1	Х.Тунгалаг	У.Өнөрсайхан	Г.Ганзориг
2	Б.Бямбажав	Л.Оргилбаяр	Б.Нацагдорж
3	Э.Тунгалагуяа	Ж.Эрдэнэбилэг	Б.Лхагвасүрэн
4	Б.Туул	Ч.Бат-Өлзий	Ч.Буянхишиг
5	Ц.Хишигжаргал	Д.Мөнх-Эрдэнэ	Б.Лхагвабаяр
6	Д.Отгонсүрэн	Ц.Рэнцэнсамбуу	Н.Цэрэнбүжид
7	Б.Мягмаржав	О.Эрдэнэцэцэг	Н.Оюун-Эрдэнэ
8	Б.Хос-Эрдэнэ	С.Буянт	Б.Юнжиндулам
9	Ө.Лхагвасүрэн	Б.Маралгуа	Н.Гэрэлчимэг
10	Б.Урангэрэл	-	Б.Отгонбаяр
11	Т.Мөнхжин	-	

8. Сангийн слесарь, дуудлага хяналтын бага эмч

№	I Ээлж	II Ээлж	III Ээлж	IV Ээлж
1. Дуудлага, хяналтын баг эмч нарын хуваарь				
1.	Л.Насанхишиг	Г.Мишигдорж	Я.Ягаанхүү	П.Шийлэгбат
2. Сангийн слесар нарын хуваарь				
1.	Л.Мягмарбаяр	Т.Эрдэнэ-Очир	Д.Гантөмөр	-